

СОЛОНГОС ХЭЛНЭЭС МОНГОЛ ХЭЛНЭЭ ОРЧУУЛСАН НЭГЭН ЗОХИОЛЫН ТУХАЙД

Г. Эрдэнэчимэг⁷⁴

요약: 지난 20 여년 동안 몽골에서 한국 문학작품 번역이 매우 활발하게 이루어졌지만, 번역에 대한 비평은 거의 찾아볼 수 없습니다. 하지만 번역에 대한 심도 있는 비평이 이루어져야 번역의 수준이 향상될 수 있습니다.

저는 이번에 한국의 문학번역원 지원으로 출간된 ‘한국학의 즐거움’의 몽골어 번역본을 읽어 보았습니다. 번역본은 전반적으로 몽골어 번역이 매끄럽지 못해서 원저자의 의도를 제대로 살리지 못한 부분이 상당히 여러 군데 보였습니다. 번역이 매끄럽지 못하다는 것은 정확한 어휘 대역이 이루어지지 않았고, 번역문 몽골어의 문체가 일반 몽골인 독자들에게 생경하거나 부자연스럽다는 것입니다. 각 분야에서 왕성하게 활동 중인 필자 22 명의 원고를 몽골어로 좀 더 정확하고 매끄럽게 번역했다라면 몽골독자들이 ‘한국적인 것’을 좀 더 깊이 이해하는 계기가 되었을 것이라는 아쉬움이 남습니다.

Түлхүүр үг: Солонгос судлал, орчуулагч, орон судлаач, соёл судлал, үг оноолт, хам сэдэв

БНСУ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Технологийн Яамны харьяа Солонгос Судлалыг Дэмжих Албанаас Солонгос судлал (Korean Studies) гэдэг ухагдахууныг мэргэжлийн түвшинд тодорхойлох шаардлагатай гэж үзээд 2009 оны өвөл нэр хүндтэй эрдэмтэн судлаачдын дунд хэлэлцүүлэг өрнүүлжээ. Хэлэлцүүлгийн дүнд 2011 оны 8-р сард Их сургуулийн профессор эрдэмтэн, гүн ухаантан, яруу найрагч, утга зохиолын шүүмжлэгч зэрэг Өмнөд Солонгосын 22 соён гэгээрүүлэгчийн бичсэн өгүүллийг эмхэтгэсэн “Солонгосыг судлахын цэнгэл (한국학의 즐거움)” хэмээх бүтээл уншигчдын гарт очсон юм. Уг бүтээлийг БНСУ-ын их дээд сургуульд ахисан түвшинд суралцаж, мэргэжлээрээ чамгүй олон жил ажилласан, их дээд сургуулийн багш голцуу монгол судлаачид БНСУ-ын Утга Зохиолын Орчуулгын Хүрээлэнгийн ивээн тэтгэлгээр орчуулж, 2017 онд “Солонгос түмнийг тольдохуй” нэрээр хэвлэн монгол уншигчдын гарт хүргэв.

Аливаа бүтээлийг орчуулахад соёл судлалын үүднээс хандах, үг хэлний өнгөн бүтэц төдийгүй, түүний чанадад орших соёлын утга агуулгыг бүрнээ нээж илтгэхийг чухалчилж буй (Чимэдцэеэ.М, 2014:101-106) өдгөө үед ийм бүтээл гарсанд миний бие олзуурхсан ч уншиж үзээд урам хугарлаа. Тэгээд орчуулгын чанарын талаар хэдэн үг нэмэрлэх нь зүйтэй гэж бодов. Бичиг зохиолд уншууртай байх гэж нэг чухал чанар бий. Үг үсгийн алдаагүй, утга төгөлдөр, найруулга

⁷⁴Доктор /Ph.D./, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази Судлалын тэнхим

сайтай бүтээлийг унших нь автомашинаар зүйрлэвэл толь шиг замаар салхи сэнгэнүүлэн давхих мэт гацаж торохгүй хурдан байдаг. Уг номыг уншихад эхний хуудаснаасаа энхэл догол замаар элэг бөөрөө доргион сэгсчүүлэх мэт санагдлаа.

Мэдээж уг номын хорин хоёр өгүүллийн орчуулга бүгд уншуургүй биш. Эдгээр солонгос зохиолчдын бүтээл үнэ цэнээ алдахгүй бөгөөд ямар нэг зохиол бүтээлийг хэдэн ч хүн, хэдэн ч удаа орчуулж болох тул монгол уншигчдад илүү сайн хүргэхээр авьяас чадвараа сорих боломж бидэнд байна.

Энэ удаад бид уг номын хоёрдугаар өгүүлэл болох философич Кан Шинь жү-гийн “Солонгос хайр сэтгэл – Жаяа хэмээх нэгэн эмэгтэйн хайр”-ыг авч үзье. Зохиолч өгүүлэлдээ ХХ зууны эхэн үеийн Чосөн-ий алдарт яруу найрагч, орчуулагч Пэг сөг (1912-1996), дууч эм Ким Ёнхан хоёрын хайр сэтгэл, ялангуяа Ким Ёнханы дотоод ертөнцийг судалснаар солонгос хүний хайр сэтгэлийн тусгай (singularity) болоод нийтлэг шинж (universality) юу болохыг тодруулахыг зорьсон (강신주, 2011:36) ажээ.

Орчуулагч хүний гол үүрэг бол эх зохиолын агуулгыг нэмж хасахгүйгээр, утгыг нь төгс бус юм гэхэд төгс рүү дөхүүлсэн хэмжээнд уншигчдад хүргэх явдал юм. Орчуулах ажилдаа үнэнч, бүтээлч санаачилгатай хандан хичээл зүтгэл гаргаснаас нь хэр зэрэг ёс зүйтэй орчуулагч болохыг үнэлж ч болно.

Манай орчуулагч, гүүш нар эртнээс үгчилж орчуулахын болхи бүдүүлгийг шоолж, утгачилж орчуулахын эрхэм чухлыг (Оюунзаяа.Н, 2014:73-76) онцлон дурдаж ирсэн тул онолын нарийн ширийнийг нуршилгүй, засаж залруулуштай зүйлийг товч дурдъя.

Юуны өмнө үг ташаа оноосны улмаас утга учир нь ойлгогдохгүй зүйл цөөнгүй байна. Ташаа үгийг давтах тусам орчуулгын чанар муудах нь тодорхой. 33-р нүүрний эхний мөрөнд “хэнхэг сэтгэлзүйн өвчтөн”, 41-р нүүрт “... эрэгтэйчүүдийн дийлэнх нь хэнхэг өвчнөөр шаналж байдаг..., ... хэнхэг өвчтөнд хамгийн чухал нь өөрийн дур хүсэл ..., “Наташагүй явж чадахгүй гэдэг итгэл нь түүний хэнхэг сэтгэлзүйн баталгаа нурж байгааг харуулж байна” гэжээ. Үүнийг уншсан ямар ч монгол хүн ойлгохгүй. Орчуулагчийн хэнхэг сэтгэлзүйн өвчин гэж оноосон 강박증 гэдэг үгийг гар доорх толь бичиг, интернет сайт зэргээс нягталж үзэхэд нэг бодол, нэг үйлдлээ олон давтдаг, ийнхүү давтдагаа хэвийн бус гэж ойлгож байгаа ч больж чаддаггүй сэтгэлзүйн эмгэгийг хэлдэг юм байна. Жишээ нь, гэрээсээ гарч явтал хаалгаа цоожлоогүй мэт санаж, дахин дахин буцсаар үүднээсээ холдож чадахгүй байх, эсвэл өвчин халдах мэт санан гараа угааж арчсаар угаалтуураас холдож чадахгүй болох зэргээр хүн хүнд янз бүрээр илэрдэг байна. Өмнөд Солонгост урьд нь тун ховор байсан ийм эмгэг сүүлийн үед олширч байгаа ажээ. Мэдрэлийн эмч нар анх уг эмгэгийг сэтгэл түгших эмгэг хэмээн оношилж байснаа сүүлийн үед тусад нь авч үздэг болсон юм байна. Монголчууд бид энэ эмгэгийн талаар сайн мэдэхгүй тул сэтгэл түгших эмгэг гэж оноход болохгүй зүйлгүй мэт.

34-р нүүрт “Тиймээс бид өөрийн худал хуурмагийг илрүүлэх нь хэдий төвөг ярвигтай ч заавал бусадтай харилцаж байдаг. Өөрийн үнэн царайг илрүүлэн тайлж, нээж, тэвэрч өгөхийг найдангаа шүү дээ” гэж утгыг гажуудуулсан байна. Эхийг нягтлахад, бид өөрөө өөрийнхөө хуурамч төрхийг илрүүлэх бус харин бидний хуурамч төрхийг бусад хүн дор нь олоод харчихдаг тухай өгүүлсэн байх юм. Бас өөрийн үнэн төрхийг илрүүлж өгөхийг найдах тухай өгүүлсэнгүй. Харин жинхэнэ дүр төрхийг маань бусад хүн мэдсэн ч мэдээгүй юм шиг хандаасай гэж хүсч найддаг тухай өгүүлжээ.

Гарчиг гэдэг бол хам бичвэрийн утга санааг хэдэн үгээр томьёолж илэрхийлсэн, уншигчийн нүдэнд эн тэргүүнд тусдаг чухал зүйл. Орчуулагч эх бичвэрээ сайтар уншиж ойлгосны дараа гарчгийг хэрхэн оноохоо бодож тунгаах хэрэгтэй. Харин энд гарчгийг орчуулахдаа хайхрамжгүй хандсан тал байна. (35-р нүүр) “Жусоны дууч эмсийн бүлгэмийн дууч эм Ким Ёнхан”-ыг “Жусоны дуулаачийн бүлгэмийн дууч Ким Ёнхан” гэхээр утга нь бүдэг бүрхэг болжээ. Тэгсэн атлаа текст дотроо дууч эм гэж оноосноос үзэхэд орчуулсан зүйлээ эргэж харж, нягталж шалгаагүй юм уу гэлтэй. Тэгээд ч Ким Ёнхан дууч эм учраас л энэ хоёр хүний хайр сэтгэл эмгэнэлтэй байсныг зохиолч тайлбарлаад байгаа юм.

Хэлц үгийг ташаа орчуулсан байна. Мөн нүүрэнд “Илжиро нь .. тухайн үеийн Жусонд алтны уурхайн халуун салхийг дэгдээж байлаа” гэснийг ойлгоход хэцүү. Үгчилж орчуулбал халуун салхинд дайруулах 熱風에 휩쓸리다, утгачилбал ямар нэг зүйлд автах гэдэг хэлц үгийг “халуун салхийг дэгдээх” гэж ташаа оноожээ. Эх бичвэрийг нягтлахад “Ылжиро гудамж ... тухайн үеийн Жусон улс алтны ‘солоиролд’ автсаныг тод харуулах газар болоод байлаа” гэсэн утгатай байна. Соёлын агуулгатай орчуулга хийхэд орчуулагч тухайн цаг үеийн нөхцөл байдлыг олж мэдэх, тайлбар зүүлт хийх шаардлага заавал гардаг. Харин энэ орчуулгыг үзэхэд орчуулагч 1930-аад оны Солонгосын нөхцөл байдлыг мэдэхийн тулд эрэл хайгуул эс хийжээ гэж бодогдлоо. Дээр нь нэг ч зүүлт, тайлбар хийсэнгүй. Энд дурдаж буй “Ылжиро”-г Сөүл хотын төвд орших худалдааны гудамж гэдгийг тайлбарлахад илүүдэхгүй. Мөн Кёнсон(35-р нүүр)-ийг колоничлолын үеийн Сөүл хотын нэр гэдгийг жирийн уншигч тэр бүрий мэдэхгүй.

Мөн 38-р нүүрт “сурагч, эсвэл оюутны асран хамгаалагч” гэдэг үгийг “анги тэнхим” гэж ташаа оноосноос “... анги тэнхим шиг байр хөлсөлж амьдардаг байсан Пэг Сог...” гэсэн нь уншигчийг төөрөгдүүлэхээр болжээ. Энэ үеийн хорин дөрвөн настай залуу Пэг Сог, анги танхим шиг айхавтар том байр хөлсөлж амьдрах эдийн засгийн чадваргүй байлаа. Тийм ч учраас дууч эмийн хөлсний байраар эргэлддэг байсан байж таарна. Байр хөлсөлж бус харин хамаатныхаа ахынд толгой хавчуулж суудаг байсан тул орчуулагч хам сэдвээ сайтар ойлгох нь хэр чухал болохыг энэ ташаарлаас харж болно.

Газар усны нэрийг буруу орчуулсан, ерөнхий мэдлэг дутсанаас алдсан зүйл ч байна. Үүнд 37-р нүүрэнд “... Хятадын Дунжины үед” гэснийг монгол уншигч Хятадын эртний улс болох Зүүн Жинь улсын үед гэж ойлгохгүй. Мөн 40, 41, 43-р нүүрэнд Манжуурыг Манж гэж ташаа оноожээ. Орчуулагч хүн түүх, газарзүйн

тодорхой мэдлэгтэй байх шаардлагатайг сануулах юун. Өгүүлэлд 1920, 30-аад оны үйл явдал гарч байгаа бөгөөд Манж Чин улс энэ үед хэдийн мөхсөн байлаа. Колоничлолын эхэн үед солонгосчууд Манжуур руу шилжин суурьших нь ихэссэн бөгөөд залуу Пэг сог хайртай бүсгүйгээ дагуулаад Манжуур явахыг мөрөөддөг байжээ. Төстэй дуудлагаас нь болдог юм уу, манай оюутан залуус Манж Манжуур хоёрыг хольж хутгах нь их.

Үүнээс гадна сулхан найруулсан, утга гажуудуулсан зүйл байна. Тухайлбал, 33-р нүүрэнд, “*Ингээж бид өөрийн талаарх жинхэнэ үнэн ойлголтонд хүрдэг нь хууль юм*”, 37-р нүүрэнд “*Пэг Сог өөрөө Ким Ёнханд өгөх эмгэнэлт хүлээлтийг урьдчилан таамаглаж байсан болов уу?*”, 38-р нүүрэнд “*... ямар ч өөр сэвгүй хаш чулуу мэт бичиг номонд гэгээрсэн нэгэн...*”, “*Пэг Сог ... аавынхаа хүчинд автан Кёнсонд албадуулан гэрлэжээ*”, 39-р нүүрэнд “*эцэг эх мэт дээдлэн үздэг энэ орчлон хорвоо түүнд хичнээн аймшигтай байсныг харж болно*” гэх мэтээр тааруу найруулжээ.

Ялангуяа “...티 없이 옥 같은 군자로서...” гэснийг “... ямар ч өөр сэвгүй хаш чулуу мэт бичиг номонд гэгээрсэн нэгэн...” гэж оноосон нь тааруухан оноолт болжээ. 군자 (君子) гэдэг үгийг манай гүүш нар эртнээс эрдэмт сайд гэж орчуулж ирсэн уламжлалтай. Күнзийн сурталд төгс төгөлдөр ёс суртахуунтай хүнийг гэгээн, түүний удаад орох хүнийг эрдэмт сайд гэж нэрлэдэг ажээ⁷⁵. Күнз “Гэгээн хүнтэй учирч эс чадах аваас эрдэмт сайдтай учрах сан (論語, 述而篇)” хэмээн мөрөөдөж байжээ. Тэгэхээр зүгээр нэг бичиг номд гэгээрсэн хүн бус, харин ёс суртахууны хувьд төгс биш юм гэхэд сайтар боловсорсон хүнийг хэлж байна. Орчуулгын уламжлалаа гээхгүй, дагаж мөрдөхийн чухлыг давтан сануулъя.

Мөн 40-р нүүрт, “Наташа бид хоёр ба цагаан илжиг” гэдэг шүлэг дур булаам чанарыг илэрхийлж байгаа гэжээ. Солонгос эхэд буй 관능적 гэдэг үгийг “дур булаам чанарыг илэрхийлэх” гэж оноосон байх юм. Харин толь бичгээс нягтлахад “бэлгийн дур хүслийг өдөөх” гэсэн утгатай байна. Тэгэхээр дур булаам чанарыг илэрхийлсэн бус харин эротик шүлэг болж таарлаа. Тэгээд ч солонгос эхэд илжгээр “гачаангүй бүсгүй”-г бэлгэдсэн гэж тодорхой тайлбарласан байна.

Энэ өгүүлэлд 욕망;慾望 гэдэг үг нэлээд олон давтагдана. Үүнийг хам бичвэрээс нь хамааран “дур хүсэл”-ээс гадна “хүсэл эрмэлзэл”, “хүсэл шунал”, “хүсэл мөрөөдөл”, “хүслэн” гэж оноож болмоор. Гэтэл орчуулагч арваас есөд нь дур хүсэл гэж оноожээ. 41-р нүүрт, “*Тиймээс эрэгтэйчүүд өөр хэн нэгэн түүнд дур хүслээ илэрхийлэхэд яахаа ч мэдэхээ болих тийм мэдрэмжийг мэдрэх нь олонтаа*” гэсэн нь модон найруулгатай болсон байна. Ер нь монгол хүн мэдрэмж гэдэг үгийг яриандаа нэг их хэрэглэдэггүй. Харин сүүлийн үед англи хэлнээс орчуулсан тааруухан орчуулгын нөлөөгөөр залуус хэт “мэдрэг” болж, “цонхоор харах мэдрэмж”, “хоол идэх мэдрэмж” гэж ярих нь халаг боллоо. “Танд ямар санагдаж байна вэ?” гэснээс “Танд ямар мэдрэмж төрж байна вэ?” гэж асуувал их л соёл боловсролтой хүн мэт харагдана гэж боддог бололтой.

⁷⁵ <https://terms.naver.com/entry.nhn?docId=510170&cid=42126&categoryId=42126>

Цааш 43-р нүүрний “’өнөөдрөөс эхлэн чи миний үүрдийн эхнэр’ гэж хэлсэн өөрийн амлалтаа биелүүлэх гэсэн Пэг Согын амлалтаа зөрчсөн гэмээ ухамсарласан ухаарлыг үлдээхийг Жаяа хүссэнгүй. Мэдээж түүнд хайртай эсвэл түүний дур хүслийн объект болмоор байвал шүү дээ... тэр нь өөрийн хайрт Пэг Согыг бага ч атугай тайван амгалан байлгах арга, тэгснээрээ мөн түүнийг хүсэл сонирхлын объектоор үлдээж чадах арга гэж ч бодсон учраас тэр”, мөн 45-р нүүрний “Тухайн үедээ өөрийнх нь дур хүслийн объект болохыг л хүсэж байсан тэр бүсгүйг шийдэмгийгээр тэрхүү дур хүслийнхээ эзэн нь болгох хэрэгтэй” гэсэн хэсгийг хэдэнтээ уншаад ухаж эс дийлэв. Дээр нь алдарт яруу найрагч, дууч бүсгүй хоёрын хайр сэтгэлийг дур хүсэл төдийгөөр ойлгуулаад байвал юунд ч уярч, сэтгэл догдлох билээ? Бичгийн өндөр боловсролтой, яруу найргийг ойлгодог тэр бүсгүй Пэг Сөг-ийн өдрийн бодол, шөнийн зүүд болсон хүн байсан болов уу.

Эцэст нь дүгнэхэд :

Орчуулгын ажлын үе шатыг орчуулга хийх гэж буй хүн сайтар мэдэх шаардлагатай. Чимхлүүр, нягт нямбай ажиллагаа шаарддаг энэ ажлын тодорхой үе шатыг гүйцэтгэлгүй, бэх нь хатаагүй шахам анхны нооргоо хэвлэлийн газар руу барьж гүйдэг (Гүрбазар.Р, 1996:7-9) байж болохгүй. Орчуулагчийн солонгос бичгийн хэлний мэдлэг, монгол хэлээрээ найруулан бичих чадвар, үгийн баялаг сулхан байна. Үг ташаа оноосон зүйл цөөнгүй тул нэг бүрчлэн тоочсонгүй.

Оноосон нэрийг монгол кирилл үсгээр галиглахдаа ямар галигийн журам ашигласан нь тодорхойгүй. Солонгос хэлний оноосон нэрийг монгол хэлээр галиглах журам байдаг ч улсын хэмжээнд нэг мөр мөрдөхөөр батлаагүй байгаа тул түр орхив.

Орчуулагч хүнд орон судлаач байх хэрэг их гарна. Орчуулах гэж буй зүйлийнхээ талаар мэдлэг хомс, утга учрыг нь олоогүй бол орчуулах талаар бодох ч хэрэггүй. Орчуулагч хүн бүгдийг мэдэж чадахгүй ч зөв орчуулахын тулд эрэл хайгуул, судалгаа хийх хэрэг байнга гарна. Толь бичгээс өөр “багаж зэвсэг”-гүй ахмад үеийн орчуулагч нартай харьцуулахад интернэтийн эриний залууст эрэл хайгуул хийх нь хялбар ажил болсныг сануулах юун.

Орчуулгыг ариутган шүүх үүргээ редактор гүйцэтгэсэнгүй. Номын редактор хийх хариуцлагатай үүргийг хүлээж авсан бол нэрээ тавиад орхих бус, мэдлэг, ерөнхий боловсролоо зузаатгасны үндсэн дээр, (Ринчен.Б, (Аким.Г) 1991) ажил үүргээ үнэнчээр гүйцэтгэж, цэвэр сайхан монгол хэлээ эвдэхгүйн төлөө хичээж чармайх хэрэгтэй.

Сүүлийн хорь гаруй жилд солонгос хэлтэй орчуулагч, судлаач олширч, Солонгосын уран зохиолын 400 гаруй бүтээлийг монгол хэлээр орчуулсан ч орчуулгын шүүмж бараг гарсангүй. Цаашид чанар чансааг нь сайжруулах нэн шаардлагатай байгаа тул солонгос-монгол орчуулгын үйлсэд санаа аваасай хэмээн хэдэн үг нэмэрлэв.